



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/321/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Э.Энхбаатар Утас: 261885 Цахим хаяг: enkhbaatare@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Г.Мөнхчимэг Утас: 261740 Цахим хаяг: munkhchimegg@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ч.Мөнхбулган Утас: 261740 Цахим хаяг: munkhbulganch@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ч.ӨНӨРБАЯР ТАНАА

2025.02.25 № 07/732
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

- Худалдан авах ажиллагааг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс урсгал засвар хийлгэх, сургалтын заалны түрээсийн ажил, үйлчилгээний хүрээнд арван аж ахуй, нэгж байгууллагатай 660,179.8 мянган төгрөгийн шууд гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн;
- Процессын дахин инженерчлэлийн судалгаа, шинжилгээг хийх зөвлөх үйлчилгээ үзүүлэх 9 аж ахуй нэгж, 2 иргэнтэй нийт 382,300.0 мянган төгрөгийн гэрээг шууд худалдан авах аргаар хийсэн, мөн ажлын тайлан ирүүлээгүй, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүйгээр санхүүжилтийг бүрэн олгож, шууд зардлаар тайлагнасан зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээр санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.5, 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, 43 дугаар зүйлийн 43.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, 44 дүгээр зүйлийн 44.1 дэх

Z:\Yawsan_Bichig\2025\0225 SNAG-111.Docx

1525000439

заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн Газрын 2024 оны 234 дүгээр “Тогтоолд өөрчлөлт оруулах, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын дүрэм, бүтцийг шинэчлэн батлах тухай” тогтоолоор Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргын эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар тогтоосон байна.

Аудитын гол асуудал

Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар нь тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 12 сард баталсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3 дахь хэсэгт “Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг хуулийн цаглабарт хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалтыг хэрэгжүүлж аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	133,439,298.00	426,308,344.46
33	АВЛАГА	68,898,000.00	76,809,614.60
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	3,469,364.76
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	-	198,124.44
335	Бусад авлага	68,898,000.00	73,142,125.40
3351	Байгууллагаас авах авлага	68,898,000.00	73,142,125.40
34	УРЬДЧИЛГАА	-	111,308,339.00
3471	Урьдчилгаа тооцоо	-	111,308,339.00
34714	Томилолтын урьдчилгаа	-	111,308,339.00
35	БАРАА МАТЕРИАЛ	64,541,298.00	238,190,390.86
351	Түүхий эд материал	2,118,300.00	9,588,000.00
35110	Тусгай зориулалттай материал	2,118,300.00	9,588,000.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	-	106,321,429.00
354	Хангамжийн материал	62,422,998.00	122,280,961.86
35410	Бичиг хэргийн материал	10,295,779.50	32,261,955.34
35420	Аж ахуйн материал	16,394,017.26	7,949,827.26
35430	Сэлбэг хэрэгсэл	14,212,810.00	5,739,510.00
35440	Түлш, шатах тослох материал	671,943.99	10,159,559.30
35450	Барилгын засварын материал	19,500,000.00	19,500,000.00
35460	Хүнсний материал	259,110.00	1,760,397.00
35470	Бусад хангамжийн материал	1,089,337.25	44,909,712.96
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	948,664,607.44	1,752,475,683.10
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	948,664,607.44	1,752,475,683.10
392	Биет хөрөнгө	700,670,943.47	1,424,455,782.43
39203	Авто-тээврийн хэрэгсэл	803,700,000.00	602,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(501,129,067.35)	(477,285,104.31)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	587,290,327.06	1,264,257,467.06
39206	Хуримтлагдсан элэгдэл	(254,080,404.45)	(443,022,040.41)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	133,245,126.16	536,747,746.16
39208	Хуримтлагдсан элэгдэл	(90,113,498.79)	(111,740,747.81)
39214	Бусад үндсэн хөрөнгө	35,615,621.80	73,944,994.80
39215	Хуримтлагдсан элэгдэл	(13,857,160.96)	(21,346,533.06)
393	Биет бус хөрөнгө	247,993,663.97	328,019,900.67
39301	Программ хангамж	11,219,800.00	93,922,700.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(4,226,136.03)	(6,902,799.33)
39303	Бусад биет бус хөрөнгө	241,000,000.00	241,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,082,103,905.44	2,178,784,027.56
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,082,103,905.44	2,178,784,027.56
51	Засгийн газрын хувь оролцоо	1,082,103,905.44	2,178,784,027.56
512	Хуримтлагдсан үр дүн	987,196,905.44	2,083,877,027.56
51210	Өмнөх үеийн үр дүн	-	987,196,905.44
51220	Тайлант үеийн үр дүн	987,196,905.44	1,096,680,122.12
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	94,907,000.00	94,907,000.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,082,103,905.44	2,178,784,027.56

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	17,386,802,820.87	14,390,095,537.22
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,041,396,947.87	536,937.22
120	Нийтлэг татварын бус орлого	1,041,396,947.87	536,937.22
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,041,396,947.87	514,937.22
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,041,396,947.87	514,937.22
120009	Бусад орлого	-	22,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	16,345,405,873.00	14,389,558,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	16,345,405,873.00	14,389,558,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	16,345,405,873.00	14,389,558,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	16,235,550,478.59	13,173,958,824.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	16,235,550,478.59	13,173,958,824.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,098,218,143.33	8,976,557,491.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,934,811,507.40	4,417,394,719.32
210101	Үндсэн цалин	1,323,911,242.45	2,702,460,573.36
210102	Нэмэгдэл	374,008,590.40	839,095,600.26
210103	Унаа хоолны хөнгөлөлт	101,120,000.00	441,134,564.51
210104	Урамшуулал	135,771,674.55	434,703,981.19
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	240,596,288.06	542,982,525.20
210201	Тэтгэврийн даатгал	165,028,262.21	369,460,827.14
210202	Тэтгэмжийн даатгал	19,415,089.78	44,319,655.19
210203	ҮОМШ өвчний даатгал	15,496,871.53	22,159,828.08
210204	Ажилгүйдлийн даатгал	3,696,005.94	21,370,357.31
210205	Эрүүл мэндийн даатгал	36,960,058.60	85,671,857.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,402,180.00	185,578,100.00
210301	Гэрэл цахилгаан	24,485,020.00	22,080,000.00
210302	Түлш, халаалт	11,968,030.00	41,957,100.00
210303	Цэвэр, бохир ус	5,459,130.00	8,153,200.00
210304	Байрны түрээс	18,490,000.00	113,387,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	114,075,383.22	158,901,615.37
210401	Бичиг хэрэг	13,942,846.52	34,817,574.16
210402	Тээвэр, шатахуун	9,306,171.23	21,971,479.91
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	27,606,999.88	37,220,219.27
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	23,314,520.02	64,892,342.03
210408	Бараа материал акталсны зардал	39,904,845.57	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,095,421.00	392,851,533.46
210601	Багаж, техник хэрэгсэл	2,832,540.00	1,665,779.00
210602	Тавилга	-	13,635,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	6,011,480.00	938,387.45
210604	Урсгал засвар	24,251,401.00	376,612,167.01
2107	Томилолт, зочны зардал	93,196,069.40	689,314,508.00
210701	Гадаад албан томилолт	21,710,750.40	488,052,803.00
210702	Дотоод албан томилолт	71,485,319.00	201,261,705.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	376,365,921.00	1,220,082,507.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	361,948,666.00	927,730,117.00
210803	Даатгалын үйлчилгээ	9,492,080.00	666,252.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	951,845.00	726,796.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	174,500.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,798,830.00	290,838,342.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	245,675,373.25	1,369,451,983.60

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын 2024 санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	207,784,463.41
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	67,816,504.00	881,241,826.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	177,858,869.25	280,425,694.19
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,137,332,335.26	4,197,401,333.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,015,447,526.00	112,064,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,015,447,526.00	112,064,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,121,884,809.26	4,085,337,333.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,121,884,809.26	4,085,337,333.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,151,252,342.28	1,216,136,712.27
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	164,055,436.84	119,456,590.15
225001	Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	159,484,774.30	119,208,790.15
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	4,570,662.54	247,800.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(164,055,436.84)	(119,456,590.15)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	987,196,905.44	1,096,680,122.12

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	16,345,405,873.00	14,389,580,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	22,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	22,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	22,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	22,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	16,345,405,873.00	14,389,558,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	16,345,405,873.00	14,389,558,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	16,345,405,873.00	14,389,558,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	16,109,898,053.00	13,255,033,040.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	16,109,898,053.00	13,255,033,040.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,972,565,717.74	9,057,631,707.00
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,933,208,235.40	4,421,062,208.51
210101	Үндсэн цалин	1,323,068,223.40	2,706,128,062.55
210102	Нэмэгдэл	373,804,673.76	839,095,600.26
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	100,918,104.00	441,134,564.51
210104	Урамшуулал	135,417,234.24	434,703,981.19
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	240,596,288.06	542,982,525.21
210201	Тэтгэврийн даатгал	165,028,262.21	369,460,827.14
210202	Тэтгэмжийн даатгал	19,415,089.78	44,319,655.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,496,871.53	22,159,828.08
210204	Ажилгүйдлийн даатгал	3,696,005.94	21,370,357.31
210205	Эрүүл мэндийн даатгал	36,960,058.60	85,671,857.49
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,402,180.00	185,578,100.00
210301	Гэрэл, цахилгаан	24,485,020.00	22,080,000.00
210302	Түлш, халаалт	11,968,030.00	41,957,100.00
210303	Цэвэр, бохир ус	5,459,130.00	8,153,200.00
210304	Байрны түрээс	18,490,000.00	113,387,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	77,792,896.88	204,530,683.27
210401	Бичиг хэрэг	19,777,500.00	56,783,750.00
210402	Тээвэр, шатахуун	7,501,255.00	30,968,158.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	27,606,999.88	37,220,219.27
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	22,907,142.00	79,558,556.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	103,666,041.00	446,356,510.01
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,386,640.00	56,109,143.00
210602	Тавилга	68,898,000.00	13,635,200.00
210604	Урсгал засвар	24,381,401.00	376,612,167.01
2107	Томилолт, зочны зардал	91,647,011.40	810,097,147.00
210701	Гадаад албан томилолт	21,710,750.40	599,361,142.00
210702	Дотоод албан томилолт	69,936,261.00	210,736,005.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	397,992,221.00	1,220,082,507.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	383,574,966.00	927,730,117.00
210803	Даатгалын үйлчилгээ	9,492,080.00	666,252.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	951,845.00	726,796.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	174,500.00	121,000.00

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын 2024 санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,798,830.00	290,838,342.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	67,260,844.00	1,226,942,026.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	329,562,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	67,260,844.00	897,379,826.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,137,332,335.26	4,197,401,333.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,015,447,526.00	112,064,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,015,447,526.00	112,064,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,121,884,809.26	4,085,337,333.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,121,884,809.26	4,085,337,333.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	235,507,820.00	1,134,547,560.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	235,507,820.00	1,134,547,560.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	235,507,820.00	1,134,547,560.00
2200	Дотоод эх үүсвэрээр	235,507,820.00	1,134,547,560.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	235,507,820.00	1,134,547,560.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(235,507,820.00)	(1,134,547,560.00)
250001	Гадаад валютын ханшийн зөрүү	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	94,907,000.00	-	94,907,000.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	987,196,905.44	987,196,905.44
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	94,907,000.00	987,196,905.44	1,082,103,905.44
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	94,907,000.00	987,196,905.44	1,082,103,905.44
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	1,096,680,122.12	1,096,680,122.12
2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	94,907,000.00	2,083,877,027.56	2,178,784,027.56

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,506,607,600.00	10,304,243,267.00	4,202,364,333.00	71.0
УРСГАЛ ЗАРДАЛ	14,506,607,600.00	10,304,243,267.00	4,202,364,333.00	71.0
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,255,808,600.00	10,192,179,267.00	4,063,629,333.00	71.5
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	7,870,740,600.00	4,421,062,208.51	3,449,678,391.49	56.2
Үндсэн цалин	3,984,997,900.00	2,706,128,062.55	1,278,869,837.45	67.9
Нэмэгдэл цалин	2,891,339,900.00	839,095,600.26	2,052,244,299.74	29.0
Унаа хоолны Хөнгөлөлт	410,112,000.00	441,134,564.51	(31,022,564.51)	107.6
Урамшуулал	584,290,800.00	434,703,981.19	149,586,818.81	74.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,013,780,000.00	542,982,525.21	470,797,474.79	53.6
Тэтгэврийн даатгал	683,790,500.00	369,460,827.14	314,329,672.86	54.0
Тэтгэмжийн даатгал	80,622,400.00	44,319,655.19	36,302,744.81	55.0
ҮОМШӨ-ний даатгал	68,398,000.00	22,159,828.08	46,238,171.92	32.4
Ажилгүйдлийн даатгал	18,724,400.00	21,370,357.31	(2,645,957.31)	114.1
Эрүүл мэндийн даатгал	162,244,700.00	85,671,857.49	76,572,842.51	52.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	185,578,100.00	185,578,100.00	-	100.0
Гэрэл, цахилгаан	22,080,000.00	22,080,000.00	-	100.0
Түлш, халаалт	41,957,100.00	41,957,100.00	-	100.0
Цэвэр, бохир ус	8,153,200.00	8,153,200.00	-	100.0
Байрны түрээс	113,387,800.00	113,387,800.00	-	100.0
Хангамж, бараа материалын зардал	231,316,100.00	208,358,683.27	22,957,416.73	90.1
Бичиг хэрэг	59,901,000.00	56,783,750.00	3,117,250.00	94.8
Тээвэр, шатахуун	34,901,000.00	30,968,158.00	3,932,842.00	88.7
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	46,613,100.00	37,220,219.27	9,392,880.73	79.8
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	89,901,000.00	83,386,556.00	6,514,444.00	92.8
Эд хогшил, урсгал засварын зардал	1,553,441,500.00	1,529,968,487.01	23,473,012.99	98.5
Багаж, техник, хэрэгсэл	818,441,500.00	818,441,500.00	-	100.0
Тавилга	335,000,000.00	334,914,820.00	85,180.00	100.0
Урсгал засвар	400,000,000.00	376,612,167.01	23,387,832.99	94.2
Томилолт, зочны зардал	815,774,000.00	810,097,147.00	5,676,853.00	99.3
Гадаад албан томилолт	599,762,400.00	599,361,142.00	401,258.00	99.9
Дотоод албан томилолт	216,011,600.00	210,736,005.00	5,275,595.00	97.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,323,248,300.00	1,232,666,090.00	90,582,210.00	93.2
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	986,820,300.00	937,410,800.00	49,409,500.00	95.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,371,300.00	-	6,371,300.00	-
Даатгалын үйлчилгээ	10,923,000.00	666,252.00	10,256,748.00	6.1
Тээврийн хэрэгслийн татвар	958,000.00	726,796.00	231,204.00	75.9
Тээврийн хэрэгслийн оношилгоо	174,500.00	121,000.00	53,500.00	69.3

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын 2024 санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Мэдээлэл, технологийн үйлчилгээ	316,825,000.00	293,741,242.00	23,083,758.00	92.7
Газрын төлбөр	1,176,200.00	-	1,176,200.00	-
Бараа үйлчилгээний бусад зардал	1,261,930,000.00	1,261,466,026.00	463,974.00	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	350,000,000.00	350,000,000.00	-	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	911,930,000.00	911,466,026.00	463,974.00	99.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	250,799,000.00	112,064,000.00	138,735,000.00	44.7
Бусад урсгал шилжүүлэг	250,799,000.00	112,064,000.00	138,735,000.00	44.7
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	142,500,000.00	112,064,000.00	30,436,000.00	78.6
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	108,299,000.00	-	108,299,000.00	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	14,506,607,600.00	14,389,558,600.00	117,049,000.00	99.2
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	14,506,607,600.00	14,389,558,600.00	117,049,000.00	99.2
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	14,506,607,600.00	14,389,558,600.00	117,049,000.00	99.2

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 79,800.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг санхүүгийн тайланд залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тайлант онд гэрээгээр гүйцэтгүүлсэн 79,800.0 мянган төгрөгийн үнэ бүхий программ хангамжийг шууд зардлаар тайлагнасан байна.	1	79,800.0			1	79,800.0	1	79,800.0				
Дүн	1	79,800.0			1	79,800.0	1	79,800.0				

3.2 Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,217,228.1 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 1,217,228.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 6 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Сахилгын шийтгэл ногдуулах	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Жилийн эцсийн санхүүгийн тайланд байгууллагаас авах 73,340.3 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.	1	73,340.3			1	73,340.3				
Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төрийн Аудитын байгууллагад аудит хийлгүүлэхээр ирүүлсэн жилийн эцсийн санхүүгийн тайланд урсгал төсвийн болон төсвийн тохируулгын тайланг иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна.	1	-					1	-		
Тайлант оны эцэст төсвийн зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсвийн дансанд бүрэн төвлөрүүлээгүй, урьдчилгаа дансанд 41,308.3 мянган төгрөгийн албан томилолтын зардлыг шилжүүлж, тайлагнасан байна.	1	41,308.0			1	41,308.0				
Худалдан авах ажиллагааг үндэслэлтэй төлөвлөж зохион байгуулаагүйгээс нийт 660,179.8 мянган төгрөгийн ажил, үйлчилгээг 10 аж ахуй нэгж байгууллагаар шууд гэрээгээр гүйцэтгүүлсэн байна.	1	660,179.8			1	660,179.8				
Процессын дахин инженерчлэлийн судалгаа, шинжилгээний зөвлөх үйлчилгээг 9 аж ахуй нэгж, 2 иргэнтэй 382,300.0 мянган шууд гэрээ байгуулж, санхүүжилтийг бүрэн олгосон боловч, гэрээг дүгнэж	1	382,300.0			1	382,300.0				

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын 2024 санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

акт үйлдээгүй, ажил, гүйлгээг шууд зардалд бүртгэсэн байна.										
Тухайн байгууллагын үндсэн чиг үүрэгт хамааралгүй мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтлэхэд 60,100.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	60,100.0			1	60,100.0				
Тайлант оны 12 дугаар сард 16,200.0 мянган төгрөгийн шатахуун талоны худалдан авч нөөц үүсгэсэн ба 6,450.0 мянган төгрөгийг шатахуун талоныг үйл ажиллагаанд зарцуулж, 9,750.0 мянган төгрөгийн шатахуун талоны үлдэгдэлтэй байна.	1				1					
Дүн	7	1,217,228.1			6	1,217,228.1	1	-		

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудитаар нийт 139,465.7 мянган төгрөгийн зөрчилд 139,465.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудсанд байршуулах 189 мэдээллээс 6 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	-					1	-
Дүн	1	-					1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Засгийн Газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргын 2023 оны А/01 дугаар тушаалаар тус газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн орон тоо, албан тушаалын жагсаалтын баталж, тус тушаалд гэрээт ажилтны орон тоог 19 хүнээр баталсан байна. Гэрээгээр ажил гүйцэтгэх ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулж цагийн бүртгэлийг үндэслэн цалинг бүрэн олгосон байна. Тайлант онд 16 гэрээт ажилтныг томилж, хөдөлмөрийн гэрээг баталгаажуулаагүй 139,465.7 мянган төгрөгийн цалинг үндсэн цалингийн зардлаас олгосон байна.	1	139,465.7			1	139,465.7		
Жилийн эцсийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогын илтгэх хуудас болон дэлгэрэнгүй бүртгэл хангалтгүй, Нягтлан бодогч, эд хариуцагч солигдох үед хөрөнгийн тооллого хийж, ажил хүлээлцээгүй байна.	1						1	
Дүн	2	139,465.7			1	139,465.7	1	
Нийт дүн	3	139,465.7	-	-	1	139,465.7	1	